

2012 оны 12 сарын 28
(7-р хэвлэл)



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ И-СОНИН

“Милленниум Ай Ти” арилжаа, төлбөр, тооцоо, хяналт, хадгаламжийн цогц системийг хүлээн авах ёслолын арга хэмжээ боллоо.

Мэдээний тойм:

- “Милленниум Ай Ти” арилжаа, төлбөр, тооцоо, хяналт, хадгаламжийн цогц системийг хүлээн авах ёслолын арга хэмжээ боллоо.
- Зах зээлийн мэдээ
- Бүртгэлтэй компаниудын мэдээ

Монгол Улсын Засгийн газраас дотоодын хөрөнгийн зах зээлийг шинэчилж, олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх зорилгын хүрээнд, 2011 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр ТӨХ, МХБ болон Лондонгийн Хөрөнгийн Бирж Групп (ЛХБГ) нь “Ажлын мастер гэрээ”-г байгуулж, стратеги болон менежментийн түвшинд хамтран ажиллаж эхэлснээр дотоодын хөрөнгийн зах зээлийн шинэчлэлийн ажил эхэлсэн билээ.

Гэрээнд тусгагдсаны дагуу, дотоодын хөрөнгийн зах зээлийн програм хангамжийг шинэчлэх зорилгыг хэрэгжүүлж 2012 оны 7-р сарын 2-нд “Милениум Ай Ти” системийг зах зээлд нэвтрүүлээд байсан бол 2012 оны 12-р сарын 17-ны өдөр энэхүү системийг хүлээн авах ёслолын арга хэмжээ болж өндөрлөв.


Энэхүү ёслолын арга хэмжээг нээн Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг үг хэлж, ЛХБГ-ын Стратеги хариуцсан захирал Дэвид

Лэстер, ТӨХ-ны Бүтцийн өөрчлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх газрын дарга бөгөөд МХБ-ийн ТУЗ-ийн дарга М.Батгэрэл, СЗХ-ны дэд дарга Б.Даажамба, Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал Х.Алтай нарын хамтаар “Милленниум Ай Ти” системийг хүлээн авах ёслолын туузыг хайчлан цан цохисноор 2012 оны 12-р сарын 17-ны өдрийн арилжааг албан ёсоор нээв. (үргэлжлэл 2-р нүүрт)



Зах зээлийн мэдээ

TOP-20 индексийн үзүүлэлт /сүүлийн 2 долоо хоногт/



2012 оны 12 сарын 17-ноос 2012 оны 12 сарын 28-ны хооронд нийт 10 удаагийн арилжаа явагдаж, 73 компанийн 699.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий 677.9 мянган ширхэг хувьцаа арилжсан байна.

Уг хугацаанд хамгийн идэвхтэй арилжигдсан компани нь “Шарын гол” ХК /229.7 сая.төг/, “АПУ” ХК /102.4 сая.төг/, “БиДиСек” ХК /73.1 сая.төг/ байсан байна.

Монголын хөрөнгийн бирж

2 долоо хоногийн:

Арилжигдсан ширхэг	677.9 мянга
Арилжигдсан дүн	699.0 сая.төг
Арилжигдсан компанийн тоо	73
Хамгийн их өсөлттэй:	Чацаргана /CHR/ +33.3%

Хамгийн их бууралттай:

Нако түлш /NKT/ +24.2%
Говь /GOV/ +22.9%
Эрээн цав /ECV/ -15.0%
Нэхээсгүй эдлэл /NXE/ -11.2%
Монгол савхи /UYN/ - 10.1%

Зах зээлийн үнэлгээ:

TOP-20 индексийн өөрчлөлт:

1,799.9 тэрбум.төг
17,714.51 / +3.99%

Индекс:
Вебсайт:

TOP-20
www.mse.mn

2012 оны 12 сарын 28
(7-р хэвлэл)



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ И-СОНИН

(үргэлжлэл)

Ёслолын арга хэмжээний үеэр Ерөнхий сайд Н.Алтанхуяг санхүүгийн тогтолцоонд сул байр суурьтай байсан хөрөнгийн зах зээлд Монгол Улсын иргэн бүр оролцон ашиг шимийг нь хүртэх боломж бүрдэж буйг онцлон, зах зээлийн шинэчилсэн тогтолцоонд олон улсын стандартын дагуу ажиллах болсон нь Монголын хөрөнгийн зах зээлийн хоёр дахь давалгаа хэмээн тодотгож, иргэд, аж ахуйн нэгжүүд хөрөнгөө арвижуулах эдийн засгийн том талбар гэж харж байгаагаа дурдсан бол ЛХБГ-ын Стратеги хариуцсан захирал Дэвид Лэстер бусад оронд хэдэн арван жилээр хөгжүүлэн жигдрүүлдэг энэхүү зах зээлийн дэд бүтцэд Монгол Улсын хөрөнгийн зах зээл ердөө 18 сарын дотор бүрэн шилжсэн нь том амжилт хэмээн тус тус дүгнэж хөрөнгийн зах зээлийг шинэчлэн хөгжүүлэх ажлын үр дүнг үнэллээ.



Тус арга хэмжээнд Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, хамт олноос гадна Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Төрийн өмчийн хорооны дарга асан Д.Сугар Уул, уурхайн дэд сайд Б.Эрдэнэбулган, Монголд суугаа Их Британийн Элчин Сайдын бие

төлөөлөгч ноён Жулиан Пирс, Лондонгийн хөрөнгийн биржийн удирдах албан тушаалтнууд, “Миллениум Ай Ти” компанийн баг бүрэлдэхүүн, брокер, дилерийн компаниудын төлөөлөгчид болон бусад холбогдох албан тушаалтнууд байлцсан юм.

“Монголын гэгээ” ХК-ийн 77.75 хувийг эзэмшигч талаас бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа хувьцааг худалдан авах саналыг СЗХ-оос зөвшөөрлөө

Санхүүгийн зохицуулах хорооноос “Монголын гэгээ” ХК (MSE:GGE)-ийн нийт гаргасан 271,805 ширхэг хувьцааны 77.75 хувь буюу 221,321 ширхэг хувьцааг эзэмшигч нэгдмэл сонирхолтой этгээд болох Г.Отгонбаяр, А.Гүррагчаа, Г.Энхбаатар, Г.Алимаа, Г.Энхтөр, Г.Бат-Эрдэнэ нараас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 22,25 хувь буюу 60,484 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 1051 /нэг мянга тавин нэг/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоног байхаар тогтоол гаргав.

“Бөхөг” ХК-ийн 92 хувийг эзэмшигч талаас бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа хувьцааг худалдан авах саналыг СЗХ-оос зөвшөөрлөө

Санхүүгийн зохицуулах хорооноос “Бөхөг” ХК (MSE:BHG)-ийн нийт гаргасан 457,293 ширхэг хувьцааны 92 хувь буюу 420,718 ширхэг хувьцааг эзэмшигч нэгдмэл сонирхолтой этгээд болох Ц.Чанцал, Ц.Ганцэцэг, Э.Гэрэлт-Од нараас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 8 хувь буюу 36,575 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 2837 /хоёр мянга найман зуун гучин долоо/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоног байхаар тогтоол гаргав.